



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 12 өдөр

Дугаар A/08

Марен сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 21 дүгээр зүйлийн 21.3.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчидийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээг шинээр төгтоосонтой холбогдуулан шугам сүлжээтэй бүсэд нэмэгдэж орсон Мөрөн сумын Засаг даргын шийдвэрээр олгогдсон нэгж талбарын хувийн хэргийг шилжүүлэн авч аймгийн Засаг даргын шийдвэр гаргуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: 3.Нямбаяр  
(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын, газрын удирдлагын хэлтсийн дарга)  
Гишүүд: Д.Идэрмөнх  
(Мөрөн сумын Засаг даргын орлогч)  
Х.Даваасүрэн  
(Аймгийн ерөнхий архитектор)  
Л.Гомбодорж  
(Мөрөн сумын газрын даамал)  
Г.Нарантуяа  
(Мөрөн сумын газрын даамал)

Нарийн бичгийн дарга: Б.Энхмаа  
(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын мэргэжилтэн)

2. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн нэгж талбарын хувийн хэргийг татан авч аймгийн Засаг даргын захирамжийн төсөл бэлтгэж 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (3.Нямбаяр)-д даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН